



МОНГОЛ САВХИ

ХУВЬЦААТ КОМПАНИ

2026 оны 03 сарын 16 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. "Монгол савхи" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 10.00 цагт "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

- Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан
- Компанийн ТУЗ-ийн тайлан
- Аудитын хорооны тайлан
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох

3. Хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилон ажиллуулсугай.

- Комиссын дарга: Э.Мөнхсайхан
- Комиссын гишүүд: П.Мөнгөнцэцэг, Д. Мөнхсайхан

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г. Ганчимэгийг томилсугай.

5. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

- Комиссын дарга: Д. Сүрэнхорол
- Комиссын гишүүд: Г.Хүрэлбаатар, О. Гантуяа

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар мэдээг хүргэх, хуралтай холбогдох асуудлыг зохих хууль, журмын дагуу эрхлэн явуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.

7. Ээлжит хурлын зарыг олон нийтэд хүргэх өдрийг 2026 оны 03 дугаар сарын 20-ний өдрөөр, бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дугаар сарын 06-ны өдрөөр тус тус тогтоосугай.

8. Хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримттай танилцах бүрэн эрхтэй болохыг дурьдсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудасны агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.

10. Саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2026 оны 04 дүгээр сарын 24-ны өдрийн 10.00 цагаар тасалбар болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА



Г.ГАНЧИМЭГ